



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

**Монгол Улсын Засгийн газрын
2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт
АмЧам Монголын өгөх санал**



Улаанбаатар 2020

Энэхүү бодлогын баримт бичгийг Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) боловсруулсан болно.

Бодлогын баримт бичгийг бүтнээр, эсвэл хэсэгчлэн дахин хэвлэхэд АмЧам Монголоос зөвшөөрөл авна.

Зохиогчийн эрх © Монгол дахь Америкийн Худалдааны Танхим

2020 оны 8-р сар, Улаанбаатар хот



Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт АмЧам Монголын өгөх санал

Оршил

2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнд Ерөнхий Сайд У.Хүрэлсүхийн тэргүүлсэн Монгол Улсын Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсан бөгөөд 2020-2024 онд хэрэгжүүлэх Засгийн газрын мөрийн хөтөлбөрт оруулах саналуудаа ирүүлэхийг Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол)-аас албан ёсоор хүссэн билээ.

АмЧам Монгол нь Монгол Улсын өнөөгийн нийгэм, эдийн засгийн асуудлуудыг хүчтэй, өрсөлдөх чадвартай хувийн хэвшлийн өсөлтөөр шийдвэрлэх боломжтой гэж итгэдэг. Түүнчлэн хувийн хэвшилд суурилсан эдийн засаг нь улс орны тогтвортой хөгжлийг болон Монголчуудын одоогийн болон ирээдүйн хойч үеийн сайн сайхан байдлыг хангах болно.

Бодлогын зөвлөмжүүд

АмЧам Монгол-ын гишүүдээс ирүүлсэн саналууд болон манай Өсөлтөд Хүрэх Зам 2020 бодлогын баримт бичиг дээр үндэслэн, бид нь дараах бодлогын зөвлөмжүүдийг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр тусгахыг санал болгож байна. Үүнд:

1. Цаашид санхүүгийн хүндрэлээс сэргийлэхийн тулд саарал/хар жагсаалтын асуудлыг банк болон санхүүгийн салбарт иж бүрэн шинэчлэлийг хийж ийм нөхцөл байдал дахин давтагдахгүй бат бөх платформ хөгжүүлэх дараах арга хэмжээг авах:

- Монгол улсыг ФАТФ-н саарал жагсаалт болон Европын Холбооны хар жагсаалтаас тэдний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх замаар нэн даруй гаргах
- ОУВС-гийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл болох Монголын банкуудыг эх үүсвэр нь тодорхой өөрийн хөрөнгөтэй, эрүүл банкууд болгож, мөнгө угаахтай тэмцэх ажлыг бүрэн хэрэгжүүлэх
- Хөрөнгийн биржэд бүртгэлтэй компаниудыг арилжааны гүйлгээ хийхдээ Монголбанкнаас зөвшөөрөл авдаг байдлыг зогсоох
- Өргөдөл гаргаснаас хойш хоёр долоо хоногийн дотор аж ахуйн нэгжид илүү төлсөн татвар, НӨАТ-ыг автоматаар буцаан олгох
- Онцгой албан татварын тухай хуульд 2021-2025 оныг хамарсан урт хугацааны онцгой албан татварын төлөвлөгөө гаргах. Урт хугацааны төлөвлөлт нь онцгой албан татварын орлогыг урьдчилан таамаглах, буурсан гаалийн татварын орлогыг нөхөх, үнийн хямрал болон зах зээл дэх тогтворгүй байдлаас зайлсхийх боломжийг олгоно.

2. Төрийн өмчит компаниудыг хувьчлан, зоригтой шинэчлэл хийж компанийн сайн засаглалын бодлогыг нэвтрүүлэх нь авлигаас сэргийлэх, албан тушаалаа урвуулан ашиглах боломжийг бууруулна

- Төрийн өмчит компаниудыг, тухайлбал Эрдэнэс Монгол ХХК-ийг хувьчлах
- Төрийн өмчит уул уурхайн компаниудыг чадавхижуулж, хүчин чадлыг сайжруулах
- Уул уурхайн салбарт сайн засаглал, ил тод байдлыг нэмэгдүүлэхийг тулд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг үргэлжлүүлэн дэмжиж, бэхжүүлэх



3. Төр, хувийн хэвшлийн хамтран ажиллах тогтолцоог бүрэн хэлбэржүүлж, Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар хөрөнгө оруулалтын гаатай орчныг бүрдүүлэх

- Гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаниудад тэгш боломж олгох, төр засаг болон орон нутгийн засаг захиргаа тэдэнтэй шударга бөгөөд хүндэтгэлтэй хандах
- Бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх тал дээр төрийн байгууллагуудыг чадавхжуулах
- Төрийн албан хаагчдын дунд авлига, хээл хахууль газар авсныг бууруулах.

4. Гуравдагч хөршийн гадаад бодлогыг тууштай баримталж, АНУ болон бусад орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээрүүд байгуулах замаар түншлэлийг өргөжүүлэх

- АНУ - Монгол Улсын хооронд байгуулсан Ил тод байдлын гэрээний хэрэгжилтийг хангах
- Монгол улсын гадаад бодлогыг тэнцвэржүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын дипломат бодлогыг хэрэгжүүлэх

5. Ажлын байрыг нэмэгдүүлэх:

- Гадаадын ажилчид болон бизнес эрхлэгчдийг Монгол улсад энэ оны 8, 9-р сард өндөр түвшний хяналт, тодорхой хязгаарлалтын нөхцөлтэйгээр нэвтрүүлэх арга хэмжээг авах, жишээлбэл, 6 сараас багагүй хугацаагаар нэвтрүүлэх, эдгээр мэргэжилтнүүдийн цалин хөлсийг боломжит доод түвшингээр буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэхүйц хэмжээгээр олгох, тэднийг холбогдох дүрэм, журмын дагуу (ажил олгогч зардлыг нь гаргах нөхцөлтэйгээр) гурван долоо хоногоор тусгаарлах
- МИАТ-ын болон бусад зорчигч тээврийн онгоцнуудыг яаралтай экспорт болон импортын логистикийн дарамтыг хөнгөвчлөх зорилгоор агаарын тээвэрт ашиглах
- Цар тахлын үед бага хүүтэй, урт хугацааны зээлийг (ААН-ийн орлогын албан татварын 50 хүртэлх хувийн төлсөн дүнтэй тэнцэхүйц) бүх жижиг дунд үйлдвэрлэгчдэд хүртээмжтэй болгох замаар хувийн хэвшлийн өрсөлдөөн болон тогтвортой байдлыг дэмжих
- Засгийн Газрын Инновацийн Санг байгуулах, тухайлбал иргэдийн өдөр тутмын амьдралын хүндрэлтэй нөхцөл байдлуудыг шийдвэрлэх санал санаачлагуудыг гаргах. Жишээлбэл, цахим сургалт, 3D хэвлэл гэх мэт.

6. Мега болон томоохон төслүүдийг урагшлуулах

- Оюутолгойн далд уурхай, Тавантолгойн цахилгаан станц, хийн хоолой, төмөр замын томоохон төслүүд, (сэргээгдэх болон уламжлалт) эрчим хүчний төслүүд, эрүүл мэндийн салбарыг сайжруулах төсөл, шинэ онгоцны буудал гэх зэрэг хүнд суртлын улмаас саатсан мега, томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг хурдасгах
- Улс орны богино болон урт хугацааны нийгэм, эдийн засгийн өсөлтөнд чухал шаардлагатай мега төслүүдийн хөгжүүлэлт болон хэрэгжилтийг зохицуулан менежмент хийдэг Мега төслийн нэгжийг байгуулах

7. Хууль эрх зүйн орчинд шинэчлэл хийх

- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Татварын тухай хууль болон бусад хууль тогтоомж зэрэг гадаадын хөрөнгө оруулалт, татварын талаархи хууль тогтоомжуудын зөрүүг арилгаж, уялдаатай болгох.
- Гэрээ байгуулсан талууд үүргээ бүрэн биелүүлдэг болох дадлыг хэвшүүлэхэд дэмжих, холбогдох эрх зүйн орчинг сайжруулах, хуулийг дээдлэх, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалт, бизнесийг урамшуулах;
- Ажлын байран дахь бэлгийн дарамт, ялгаварлан гадуурхалтын талаарх хууль тогтоомжийг шинэчлэх.

8. Төрийн болон орон нутгийн засаг захиргааны түвшинд бодлогыг уялдуулах.

- Төрийн болон орон нутгийн засаг захиргааны хоорондын бодлого, засгийн газрын шийдвэрүүдийн уялдаагүй байдлыг багасгах. Улаанбаатар хотод хүчинтэй шийдвэрийг орон нутгийн засаг захиргааны байгууллагууд ихэвчлэн үгүйсгэдэг буюу таггалздаг нь бизнес эрхлэгчдэд маш их бэрхшээл учруулдаг.

9. Дижитал шилжилт ба цахим засаглал

Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн салбарт шинэ засгийн газрын үед дорвитой ахиц дэвшил гарна хэмээн найдаж, дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

- Ковид-19 цах тахлын улмаас бизнес загварууд хурдан өөрчлөгдөж буй энэ үед МХХТ, харилцаа холбооны сүүлийн үеийн технологиудыг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулах.
- Мэдээллийн технологийн боловсролд зоригтой хөрөнгө оруулалт хийх - Монгол компаниуд байгаа хэдий ч олон улсад бэлтгэгдсэн инженерүүд дутагдаж байна.
- Дэд бүтцийн болон МХХТ-той холбоотой хуулиудыг нэг төрийн байгууллагын эрх мэдэл дор зангидах. Одоогоор дангаар нь бүрэн хариуцсан байгууллага байхгүй байна. Харилцаа холбооны компаниуд зах зээлээ өөрсөддөө хадгалж, дохио хуваалцахгүй, менежментийн бодлогогүйгээр бараг л олигополийн зах зээл болгон хувиргадаг. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн давтамжийн менежментийн стандарт, лицензүүдийг ашигладаггүй,
- Банк, банк бус санхүүгийн байгууллагууд, бусад салбарыг олон улсын дата төвүүд болон cloud платформуудыг ашиглахыг зөвшөөрөх. Эдгээр нь илүү хямд байдаг ба Монгол улсын хуулиар одоогоор зөвхөн дотоодынхыг ашиглахыг зөвшөөрдөг. Энэ нь инновацийг үндэсний үйлчилгээ үзүүлэгчид болон тэдний хэрэглэгчдээс хааж буй явдал юм.
- КҮС ба AML-ийн нүүр нүүрээ хардаггүй технологийг зөвшөөрөх: Бүхий л технологи байдаг боловч цаг үеэсээ хоцорсон хуулийн улмаас эдгээр технологийг ашиглах боломжгүй байна. Ялангуяа цар тахлын энэ үед хамгийн их хэрэгцээтэй үйлчилгээ нь санхүүгийн үйлчилгээ бөгөөд олон хүмүүс эдгээр үйлчилгээнд хамрагдах боломжгүй байна. Түүнчлэн бүх зүйл олон улсын стандартад шилжвэл, бусад банк, улс орнууд Монголын банкуудын бүртгэл, тооцоог дижитал хэлбэрээр хүлээн авч, саарал жагсаалтад орох эрсдлийг бууруулж чадна.

- Энэ салбарт sandbox-г эхлүүлж, тогтвортой хөгжүүлэх: Sandbox гэдэг нь финтек гарааны компаниуд болон бусад шинийг санаачлагчдад хуулийн байгууллагын зааварчилгаа дор хяналттай орчинд жинхэнэ туршилт хийх боломжийг олгодог хууль эрхзүйн орчин юм. Энэхүү туршилтын хууль эрхзүйн орчин нь fintech салбарын амжилтанд чухал ач холбогдолтой бөгөөд хөгжиж буй оронд инновацийн хөдөлгөгч гол хүчин зүйл байдаг. Одоогийн байдлаар 32 улс туршилтын эрхзүйн орчинг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд араас нь 11 улс энэхүү хууль эрхзүйн орчинг хэрэгжүүлж эхлэхээ албан ёсоор зарлаад байна.

Зарим улс орнууд энэхүү хууль эрхзүйн орчинг амжилттай туршсаны үр дүнд одоогийн журам, лицензийн шаардлагыг өөрчлөх тухай хуулийн төслийг боловсруулж эхлэв.

Одоогийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) fintech байгууллагууд болон Монголын Финтек Холбооны гишүүдтэй хамтран Монгол Улсад энэхүү туршилтын хууль эрхзүйн орчин хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан. Илүү сайн үйлчилгээ, бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхийн тулд fintech компаниуд СЗХ, Монгол банкнаас албан ёсны зөвшөөрөл авах шаардлагатай.

Арабын нэгдсэн эмират улс зэрэг орнууд Fintech-ийг хөгжүүлэх асуудлыг нэн тэргүүнд тавьж байна. Тэд Тэдний Fintech Sandbox нь технологийн салбарт хамгийн оновчтой байрлалд байдаг юм. Дубайн стратеги бол ур чадвараа сан болгон бүс нутагтаа нэвтрэх замаар fintech инновацыг хөгжүүлэх юм. Тэд хатуу журам, лиценз нь ямар ч шинэчлэл хийх орчин бүрдүүлэхгүй гэсэн байр суурьтай байдаг. Мөн уламжлалт банкны систем нь уян хатан биш ба Ковид-19 тахал зэрэг нөхцөл байдалд хангалттай хурдан биш байна гэж үзэн уян хатан хурдан дасан зохицох чадвартай fintech салбарт тулгуурлаж ажиллаж байна.

- Open banking буюу Нээлттэй банкны үйчилгээ:

Нээлттэй банкны үйчилгээ гэдэг нь санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг гуравдагч этгээд банк болон банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн гүйлгээ болон дата системд application programming interfaces (APIs)-ыг ашиглан нээлттэй нэвтрэх эрх олгодог банкны үйлчилгээ юм. Нээлттэй банкны үйлчилгээ нь хэрэглэгчид, санхүүгийн байгууллагууд болон гуравдагч үйлчилгээ үзүүлэгч этгээдэд данснууд болон датаг хооронд нь холбох боломжтой болгодог. Энэ нь банкны салбарын ирээдүйг шийдвэрлэх гол инновац болж байна. Товчхондоо, нээлттэй банкны үйлчилгээ нь Монгол улсад банкууд болон финтек компаниудын хоорондын хамтын ажиллагаа болон хөгжилд маш чухал юм. Энэхүү хамтын ажиллагаа болон үйлчилгээг Монгол улсад нэвтрүүлэхийн тулд төрийн байгууллагууд энэхүү үйлчилгээний зорилго, үр ашгийг нь сайтар ойлгох шаардлагатай.

- МХХТ болон Цахим Эдийн Засгийн Эрхзүйн Чөлөөт Бүс

МХХТ өндөр хөгжсөн олон улс орнууд хэт хуульчилсан эрхзүйн орчинтой тул тэдний хувьд судалгаа, хөгжүүлэлт хийх орон зай дутмаг байдаг. Монгол Улс энэхүү боломжийг ашиглан, уул уурхай, хөдөө аж ахуй, боловсрол, роботик, финтек болон эрүүл мэндийн технологийн салбаруудад дэлхийн түвшний

томоохон технологийн компаниуд өөрсдийн дата төвөө байгуулах, судалгаа шинжилгээг хууль эрхзүйн орчны ямар нэг дарамтгүйгээр явуулах бүс болж, түүнчлэн дотоодынхоо хүний нөөцийг сурган, дэлхийн технологиос суралцаж, эдийн засгаа сайжруулах, татварын орлогыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой юм.

10. Тогтвортой, хариуцлагатай салбаруудыг дэмжих:

Уул уурхай:

- Уул уурхайн салбар, ялангуяа алтны салбарт тогтвортой байдлыг хангах
- Хариуцлагатай уул уурхайг бүхий л боломжтой арга хэлбэрээр дэмжих, тэр дундаа бичил уурхай эрхлэлтийг бууруулах арга хэмжээг нэмэгдүүлэх
- Хариуцлагатай болон хариуцлагагүй уул уурхайг ялгаж салгах талаар шаардлагатай арга хэмжээ авах, төслүүд хэрэгжүүлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх

Барилга:

- Хөрөнгө оруулалтын буюу Тогтвортой байдлын гэрээ байгуулсан, хөрөнгө оруулалтаа хийсэн, гэрээний үүргээ биелүүлж буй барилгын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг бодитоор дэмжих, Засгийн газрын хүлээсэн үүргээ чандлан биелүүлэхэд анхаарах

Хөдөө аж ахуй:

- Хөдөө аж ахуйн салбарын тендерийн процессыг илүү нээлттэй болгох, хямд, чанар муутай тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний оронд хамгийн сүүлийн үеийн хүчин чадал сайтай, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгох
- Засгийн газар хөдөө аж ахуйн экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн Банкны болон бусад санхүүжилтийн хувилбаруудыг санал болгож байгаа. Гадаадын хөрөнгө оруулагчид, тухайлбал шинэ технологи нэвтрүүлж буй, экспортын зах зээлд гарц гаргаж буй хөрөнгө оруулагчдыг бие дааж эсвэл дотоодын түншүүдтэй хамтарсан хэлбэрээр бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Иймэрхүү төслүүдийг дэмжихээр сонгохдоо инновац, орон нутагт нэмүү өртөг шингээж буй байдал, төслийн урт хугацааны тогтвортой байдал зэргийг гол шалгуур үзүүлэлтүүд болгон харах шаардлагатай байна.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, ялангуяа мах, сүүн бүтээгдэхүүний талаар засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах талаар яаралтай анхаарах хэрэгтэй байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр:

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулагдах гэж байгаатай холбогдуулан газрын тосны нөөцийг нэмэгдүүлэх үүднээс хайгуул, олборлолтыг эрчимжүүлэх, төр засгаас бүхий л шатанд дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт, татварын таатай орчныг бий болгох замаар эрсдэл өндөртэй энэ салбар дахь гадны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ерөнхий гол зорилгын хүрээнд дор дүрдсэн тодорхой арга хэмжээнүүдийг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт түсгуулах саналтай байна. Үүнд:

- Газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох: хууль тогтоомж, дүрэм журмын давхардал, гажуудлыг арилгах, илүү нарийвчилсан, тодорхой зохицуулалттай болгох, мэргэжлийн нэр томъёог нэг мөр болгох, олон улсын чиг хандлага, сайн түршлага бүхий салбарын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжсэн дүрэм, журам, стандартыг нэвтрүүлэх.

Жишээ нь, "нөөц" ба "баялаг" зэрэг хуулийн нэр томъёог олон улсын чиг хандлага, стандартын дагуу хуульд зөв тодорхойлж нэгдсэн нэг мөр ойлголттой болох; Газрын тосны баялгийн удирдлагын систем (Petroleum Resources Management System)-д шилжих, газрын тосны салбарт идэвхитэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудтай хууль эрх зүйн орчныг өөрчлөх, бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний зохицуулалтыг боловсронгуй болгох замаар Монгол Улсын өрсөлдөх чадварыг хэрхэн дээшлүүлэх талаар санал солилцож хамтран ажиллах.

- Төрийн байгууллагууд хоорондын ажлын уялдаа холбоо, үр дүнтэй байдлыг сайжруулах замаар газрын тосны хайгуул, олборлолтын салбарыг бодлогоор дэмжин асуудлыг түргэн шуурхай шийддэг байх. Газрын тосны олборлолтын салбарт төрийн оролцоог зохистой төвшинд байлгаж тусгай зөвшөөрөл олгох, ашиглалт явуулахад шаардагдах бүхий л төрлийн зөвшөөрөл, бүртгэлийн процессыг хөнгөн шуурхай, боловсронгуй, тодорхой, чирэгдэл багатай болгох.
- Орон нутгийг мэдээллээр хангах, сургалт сүрталчилгаа явуулах зэргээр газрын тосны салбарт баримтлах төрийн бодлого, байр суурийг орон нутгийн удирдлагууд, иргэд, аймаг, сум, багийн бүх түвшинд таниулан, нэгдмэл босоо бодлоготой байлгах. Газрын тос хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулдаг БХГ-ний төлбөр, үрамшууллаас орон нутгийн хүртэх хувь хэмжээ, зохицуулалтуудыг ил тод байлгах. Орон нутагт бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж бизнес эрхлэхэд шаардлагатай дэмжлэг болон хяналтыг сайжруулснаар газрын тос олборлолтын үйл ажиллагаанд орон нутгийн бизнес эрхлэгчид оролцох бололцоог хангах.
- Газрын тосны салбарт хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн бодитой үйл ажиллагаа явуулах: хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж хоосон уриа лоозон тунхаг төдий байдлыг өөрчлөх; Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэдэх Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх г.м.
- Газрын тосны хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх. Манай улсын газрын тосны олборлолтын оргил үе 2016 онд 1.1 сая тоннд хүрч байсан. Үүнээс хойш тасралтгүй буурсаар одоо жилд 800 гаруй мянган тонныг л олборлож байна. Статистик өгөгдлүүдээс харахад энэ хэмжээ нь Үндэсний газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтанд орох үед магадгүй 600 мянган тонн болж буурах хандлага ажиглагдаж байна. Үйлдвэрийн хүчин чадал жилд 1.5 сая тонн түүхий тос боловсруулах ёстой гэж үзвэл энэ хэмжээг хангахад жилд сая орчим тонн газрын тосны олборлолтыг нэмж хийх шаардлага учрах эрсдэлтэй байна. Иймд газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, хамгийн гол нь газрын тосны хайгуулын үйл ажиллагааг яаралтай эрчимжүүлэх шаардлага зайлшгүй байна. Жишээ нь, газрын тосны эрэл, хайгуулыг эрчимжүүлэх зорилгоор удаан хугацаанд үйл ажиллагаа явуулахгүй байгаа талбайнууд дээр нээлтгүй тендер зарлан яаралтай эргэлтэнд оруулах боломжтой.


АмЧам Монгол нь эдгээр бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд танхимынхаа гишүүд болон бодлогын хороонууд, тухайлбал уул уурхай, хөдөө аж ахуй, мэдээллийн технологи, авто тээвэр болон санхүүгийн салбарт мэргэшсэн хороонуудаар дамжуулан Засгийн газартай хамтран ажиллахад бэлэн байна.

Түүнчлэн бидний зүгээс АмЧам Монгол, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар болон холбогдох яамдуудын хооронд ард иргэдэд эдийн засгийн үр өгөөжийг бий болгох ажил хэрэгч саналуудыг дэвшүүлэх, шаардлагатай мэдээллийг харилцан солилцох зорилгоор сар тутмын хоёр талт уулзалтуудыг зохион байгуулж байх саналыг хүргүүлж байна.





The *AMERICAN CHAMBER* of Commerce in Mongolia



www.amcham.mn